

ҮНДЭСНИЙ ТЕЛЕВИЗ ҮНДЭСНИЙ ЭРХ АШГИЙГ
ДЭЭДЭЛЖ ЧАДАЖ БАЙНА УУ?

Н.Ариунзаяа*

* “Отгонтэнгэр” Их сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимийн багш, сэтгүүл зүйн доктор (Ph.D)

Түлхүүр үг: радио телевиз, эфирийн цаг, ур чадвар, хөтөлбөр, мэдээллийн багтаамж, эрэмбэ, арилжааны телевиз, технологийн дэвшил, эх сурвалж, ёс зүй

Өнгөрсөн оны сүүлчээр МҮОНРТ-ийн Удирдах зөвлөлийн орон гарсан гишүүдийг нөхөн томилох үеэр УИХ-ын дарга З.Энхболд шинэ гишүүдэд захиа даалгавар өгөхдөө «Радио, телевиз гэж аймшгийн газар бий шүү. Зуун хүний хийдэг ажлыг 800 хүн хийж байгаа. Архидалт гэж замаа алдсан» гээд хэлчихсэн нь радио телевизийн удирдлагуудын уур бухимдлыг оволзуулж бүтэн долоо хоног шахам эсэргүүцэл илэрхийлцгээсэн. Хөндлөнгөөс харж байхад З.Энхболдын “аймшгийн” гэдэг үгийн тун баахан хэтэрсэн байх. Харин радио, телевизийнхний эгдүүцэл түүнээс ч долоон дор, бүр ёс зүйгүй үйлдэл болох шиг санагдсан. М.Наранбаатар тэргүүтэй байгууллагын удирдлагууд ажилтнуудаа турхирч хэдэн орой өөрсдийгөө өмөөрч үндэсний олон нийтийн телевизийн сувгаар гомдол мэдүүлж зарга хийцгээсэн.

Их хурлын дарга уран бүтээлч хамт олны хөдөлмөр зүтгэлийг дутуу үнэлсэн байхыг үгүйсгэхгүй. Тэглээ гээд олон нийтэд хэрэгтэй мэдээлэл

цацаж байх ёстой эфирийн цагаас хугаслаж хэрүүлийн суваг болгодог нь ёс зүйгүй, үзэгчдээ үл хүндэлсэн хэрэг юм. Соёлтой сэтгүүл зүйд эфирийн цаг бол олон нийтийн өмч байх ёстой. Тэгэхээр хүчирхэг мэдээллийн хэрэгслийг атгаж байгаадаа эрдэж үзэгчдийн ашигтай мэдээллийн цагийг өөрсдийгөө өмөөрөх хэрэгсэл болгосон нь нэг янзын мэдээллийн түрэмгийлэл мөн. Хэрэв аль нэг арилжааны телевизэд хөлс төлөөд тэр хэрүүлээ цацуулсан бол телевизийнхэн ёс жудагтай хүмүүс болохоо харуулах байлаа.

Болсон явдлаас үүдээд МҮОНРТ үнэхээр өөртөө хир халдаахгүй байх хэмжээнд ажиллаж чадаж байгаа юу гэх бодол төрж, зарим зүйлийг ажигласнаа энд сийрүүлэхээр шийдсэн юм. Радиоог хотынхон нэг их сонсоод байдаггүй болохоор би тодорхой юм хэлж чадахгүй. Харин телевизийн хувьд авч хэлбэл тийм ч өө сэвгүй өндөг шиг цэвэрхэн ажилладаг газар биш бололтой. Би энд тэр архи дарсны тухай ярихгүй, мэдэх ч үгүй. Зөвхөн телевизийн хөтөлбөр, тэдгээрийн ур чадвар, үр нөлөөний тухай хэдэн үг хэлэхийг хүссэн юм. Эхлээд мэдээллийн хөтөлбөрийн тухай ярья.

Амьдралын шаардлага, тулхтай мэдээлэл олж авах хэрэгцээний

үүднээс олон нийтийн хамгийн их үздэг нэвтрүүлэг бол «ММ» агентлагийн 18:00 цагийн мэдээ, «Цагийн хүрд» нэвтрүүлэг юм. Зүй нь үндэсний олон нийтийн телевизийн мэдээллийн хөтөлбөр дэлхий дахинд болон өөрийн оронд болж байгаа цаг үеийн үйл явдлуудыг ач холбогдлоор нь эрэмбэлж, чухам л үндэсний, мэргэжлийн том телевизийн буурь зааж сонгосон мэдээллүүдээс бүрдэж байх учиртай. Гэтэл ийм байж төдийлөн чадахгүй байна. Юуны өмнө «ММ» агентлагийн мэдээллийн багтаамж, сонголт тааруухан, ялангуяа УИХ завсарласан үед дээлийн цоорхой бөглөх шиг эсэн бусын юмаар аргацаадаг нь бараг хэм хэмжээ болсон юм.

2015 оны 3 дугаар сарын 27-ны «Цагийн хүрд» нэвтрүүлгээр жишээ татъя. Нэг удаад 45 минут явдаг энэ нэвтрүүлэгт байгалийн зураглал, цаг агаарын мэдээг оруулаад 14 материал багтжээ. Тэдгээрийн хамгийн товч мэдээ нь 1,5 минут, урт нь 15 минут үргэлжлэв. 7-8 минут үргэлжилсэн мэдээ хоёр байв. Ингэхээр 45 минут үргэлжилдэг нэвтрүүлгийн 30 минутыг гуравхан мэдээ эзэлчихэж байгаа юм. 15 минут үргэлжилж байгаа яриа бол яагаад ч мэдээ биш. Энэ бол бие даасан нэвтрүүлэг хийх сэдэв мөн. Ерөөсөө телевизийн мэдээ гурван минутаас илүү байх нь нэгд: мэдээний шинжээ алдах, хоёрт: үзэгчийн сонирхлыг бууруулах сөрөг нөлөөтэй байдаг. Тэрхүү 15 минутын мэдээгээр «Монголд үйлдвэрлэв» гэсэн шошготой оёмол, сүлжмэл бүтээгдэхүүн урд хилээр орж ирдэг тухай яриу. Бараг арав шахам эх сурвалж оролцсон энэ материалыг мэдээ биш сурвалжлага байсан гээд бодъё. Тэгвэл өдөр бүхэн элдэв үйл явдлаар хахаж цацаж байдаг өнөө цагт аль тэртээгээс амьдралд

нэвтрээд улиг домог болчихсон ийм сэдвийг өдрийн сурвалжлагаар сонгосон нь үнэхээр сэтгэлд хүрэхгүй байна.

Энэ нэвтрүүлгийн гадаад мэдээний хэсэгт ердөө хоёрхон мэдээ оржээ. Түүний нэг нь Францад онгоц осолдсоны буруутан нь 2 дугаар нисэгч Андреас Любиц байж магадгүй тухай долоон минут эзэлсэн мэдээ бол, нөгөөх нь хоёр Солонгосын тагнуулын маргаан байв. Дэлхий ертөнцийн асар их орон зайд бүхэл бүтэн 24 цагийн туршид энэ хоёроос өөр чихний ар луу хаячихмаар үйл явдал болсонгүй гэж үү? Гадаад мэдээний орчуулагч, редактор гээд нэг хэсэг хүн байдаг бололтой харагдаад байдаг. Тэд ээлж халаагаа авалцаад ч гэсэн даяар сүлжээнд нэвтрээд дэлхий ертөнцийн хаана нь юу болж байгааг нүд цавчилгүй харж суух нь битгий хэл компьютерийнхээ дэлгэцийг нээдэг юм болов уу гэж бодогдохоор. Хоногтоо ганц удаа явдаг мэдээллийн бүхэл бүтэн нэвтрүүлгийн туршид хорвоо ертөнцийн тухай хоёрхон мэдээ сонссон хүн сэтгэл дундуур хоцрохоос өөр яах билээ.

Зарим чухал үйл явдлыг хоцорч мэдээлэх, бүр чимээгүй өнгөрөх нь үндэсний телевизийн гэм биш зан болжээ. Жишээ нь 2013 оны сүүлчээр Украины засгийн газрын тэргүүн огцорсныг арилжааны телевизүүд бараг үйл явдалтай зэрэгцэх шахаад мэдээлж байхад үндэсний телевиз маргааш нь дуугарч байсныг санаж байна.

2015 оны 3 дугаар сарын 22-ны өдөр МҮОНТ-ийн 2 дугаар сувгаар цацсан «Ажил хэрэгч хөтөлбөр» гэдэг нэвтрүүлгээр «Менежер-карьер» институтын захирал, багш нартай ярилцав. Тэр нэвтрүүлгийн зочин «Ирэх 3 дугаар сарын 15-нд болох манай 10 жилийн ойн арга хэмжээнд оролцоорой»

хэмээн телевиз үзэгчдийг урьж байх юм. Гэтэл тэр ойн арга хэмжээ нь өнгөрөөд долоо хоночихсон байдаг. Бас хөтлөгч нь «Манай нэвтрүүлэг долоо хоног бүрийн лхагва гаригт явдаг» гэж анхааруулаад байгаа хэрнээ ням гаригт явж байх жишээтэй. Нэг нэвтрүүлэг хийчихээд олон давтаж үзүүлдэг, хуучин юмаар эфирийн цагаа бөглөдгийн хар гай энэ мөн. «Цагийн хүрд» нэвтрүүлэг л гэхэд ганц хоёр шинэ мэдээгээр хачирласныг эс тооцвол үндсэндээ 18 цагийн мэдээгээ давтдаг. Мэдээллийн технологийн дэвшлийн ачаар хүмүүс хэрэгтэй мэдээллээс хоцорсон ч ухраагаад үзчихдэг болсон өнөө үед нэг нэвтрүүлэг, ялангуяа мэдээг сурлага муутай хүүхдэд давтлага өгч байгаа юм шиг дахин дахин үзүүлэх хэрэггүй юм. Ийм юмыг үзээд энэ олон хүн юу хийж байдаг юм бол гэх сэтгэгдэл төрдгийг нуух юун.

2015 оны 6 дугаар сарын 9-ний «Цагийн хүрд» нэвтрүүлгээр Зайсангийн амны тусгай хамгаалалттай газарт олон жил суурьшсан иргэдийн хашааны газрыг баталгаажуулалгүй өдий хүрсэн тухай “мэдээ” нэвтрэв. Энэ мэдээнд Байгаль орчны сайд, тусгай хамгаалалттай газрын захиргаа болон бусад холбогдох албаны хүмүүс, иргэд гээд олон хүн оролцож санаа бодлоо хэлсэн юм. «Тусгай хамгаалалттай газар тул өмчлүүлэхгүй, зөвхөн эзэмшүүлнэ», «Том том барилга барьчихсан мөнгөтэй хүмүүсийн газрыг баталгаажуулчихаад, ядарсан иргэдийнхийг авч хэлэлцдэггүй», «Шинээр суурьшсан айлуудад хашааных нь газрыг өмчлүүлэхгүй», «Дамжуулан худалдсан бол зөвшөөрөл олгохгүй» гэх мэт зөрчилтэй олон асуудал уг мэдээнд хөндөгдөж байв. Дүгнээд үзэхээр энэ бол мэдээ мэтхэнээр илээд

өнгөрөх асуудал биш, олон эх сурвалжтай уулзаж тодорхой асуудал дэвшүүлбэл зохих нэвтрүүлгийн сэдэв байлаа.

Ийм мэдээнцэр олон нэвтрүүлэгт орон зайгаа эзэлсээр байна. 2015 оны 3 дугаар сарын 20-ны «Цагийн хүрд» нэвтрүүлгээр Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн дүгнэлтийн тухай илт нэг талыг барьсан мэдээ дамжуулав. Тэр мэдээ ард иргэдийн дунд шүүхийн шинжилгээний дүгнэлтэд үл итгэх байдал газар авсан тухай дурдаж, тэгвэл тус газрын дүгнэлтэд эргэлзэх хэрэггүй юм байна гэж ятгаад, түүнийгээ мөнөөх хүрээлэнгийн ажилтан хоёр хүний үгээр баталгаажуулж байгаа харагдав. Энэ бол цаг үеийн асуудал ч биш, мэдээ ч биш, захиалгатай ч байж мэдэх олон нийтийн тархийг угаах гэсэн хэрэг. Зүй нь маш ноцтой энэ асуудлыг няхуур нямбай судалж үнэн, худлыг хагалсан үр нөлөөтэй нэвтрүүлэг хийвэл зохих байж.

Гачууртын ордыг ашиглах, эсэх асуудлаар «ММ» агентлаг бас л нэг талыг барьсан, хатуухан хэлбэл эрх баригчдын шийдвэрийг зөвтгөж долигоносон мэдээ бэлтгэлээ. Мэдээг ажиглаад байхад иргэний хөдөлгөөн болон олон нийтийн эсэргүүцлийг намжаах зорилгоор сурвалжлагчаа зориуд илгээжээ гэж бодогдохоор байв. Сэтгүүлч Гачууртын ордыг ашиглах нь Ноён уулын дурсгалд ямар ч сөрөг нөлөөгүй юм байна гэж дахин давтан хэлсэн атлаа тэр үндэслэлээ өөрөө ч, мэргэжлийн хүнээр ч баталгаажуулсангүй. Ашигт малтмалын инженер, археологийн мэргэжилтний аль нь ч биш байж, ингэж нэг талыг барьж мэдэмхийрэх нь сэтгүүлчийн ёс зүйд харш юм.

2015 оны 5 дугаар сарын 28-ны «Цагийн хүрд»-ээр гарсан Туул голын

бохирдлыг арилгах тухай, «Нарантуул» зах дээр эрүүл ахуйн шаардлага хангахгүй хүүхдийн тоглоом зарагдаж байгаа тухай зэрэг материалууд нь мэдээ гэхэд дэндүү нуршуу, сурвалжлага гэхэд асуудлынхаа ул мөрт орж чадаагүй хэдэн хүний сэтгэгдлийн хэлхээ болжээ. Уг нь ингэж дутуу алсан могой шиг юм хийж байхын оронд хэрэг явдлыг язгуураар нь нухацтай судалж, гарах гарцыг санал болгосон үр нөлөө бүхий нэвтрүүлэг хийвэл өгөөжтэй байх сан. Жишээ болгож хоёр дахь сурвалжлага (ингэж нэрлэе)-ыг аваад үзье. «Нарантуул» зах дээр эрүүл ахуйн шаардлага хангахгүй тоглоом зарагдаж байна гэж МХЕГ-ын ажилтан хэлэхэд, Захын эрүүл ахуйч эмч тийм юм байхгүй гэж эсэргүүцлээ. Гэтэл Баянзүрх дүүргийн мэргэжлийн хяналтын байцаагч урьд нь бидний хийсэн шалгалтаар тийм зөрчил илрээгүй гэж нотлов. Ердөө л нэг ийм гурван хүний задгай яриа. Хэн нь үнэн, хэн нь худал хэлээд байгааг сэтгүүлч огт сонирхсонгүй, задгай чигээр нь хаячихлаа. Ийм юмнаас үзэгчид ямар мэдээлэл авахыг нөгөө мэдээ гаргагч редактор нь ч бодоогүй бололтой.

Эрхэм уран бүтээлчид маань нэвтрүүлж байгаа мэдээллийнхээ авцалдааг анхаардаг шинж алга. Дээр дурдсан 5 дугаар сарын 28-ны нэвтрүүлэгт нэг амаараа Дарханд газрын тос боловсруулах үйлдвэр барих ёстой байсан ч төсөв нэмэгдсэн учраас больсон» гэж хэлсэн мөртөө, нөгөө амаараа «Дорнод аймагт барих газрын тосны үйлдвэрт ажиллах мэргэжилт-

нүүдийг Хятадын Дачин хотод бэлтгэж байна» гэж ярив. Дарханд барихаар зардал нь өсөөд Дорнодод байгуулахаар хямдраад байсан юм уу, ерөөсөө Дорнодод үйлдвэр барих шийдвэр хэзээ гарсан юм, хоёуланд нь барих гэж байгаад Дарханыг болиод Дорнодыг сонгосон юм уу гэх мэт ойлгомжгүй юм энд олон байна.

Сэтгүүл зүйн мэдээллийг сонгоход өөрт хамаатай байх гэж нэг зарчим байдаг. Гэтэл тохиолдлын шинжтэй, хоёр гуравдугаар зэргийн ач холбогдолтой, заримдаа бүр огт хэрэггүй мэдээ «Цагийн хүрд»-д шургалсан байх нь цөөнгүй. Жишээ нь «Испанийн Барселона хотын нэгэн гудамжинд зэвсэгт этгээд гал нээж нэг хүний аминд хүрчээ» гэх буюу «Египетийн нийслэлийн захын

«
Сэтгүүл зүйн мэдээллийг сонгоход өөрт хамаатай байх гэж нэг зарчим байдаг. Гэтэл тохиолдлын шинжтэй, хоёр гуравдугаар зэргийн ач холбогдолтой, заримдаа бүр огт хэрэггүй мэдээ «Цагийн хүрд»-д шургалсан байх нь цөөнгүй
»

дүүрэгт орших нэгэн үйлдвэрт гал гарч 19 хүний амь үрэгджээ» гэх зэрэг мэдээ нэвтрүүлэх юм. Ертөнцийн хязгаарт байдаг, нэрийг нь дуулснаас цаашгүй улс оронд болсон ийм явдал монгол хүнд хэр зэрэг хүрэх, хүрлээ гэхэд ямар хэрэгтэй вэ гэдгийг бодох л хэрэгтэй юм. Жишээ нь Налайхын нүүрсний цооногт хэдэн хүн дарагдчихлаа гэхэд гаднын улс орнууд содон жигтэй явдал гэж үзэх үү? Геополитикийн ямар ч ач холбогдолгүй, тохиолдлын чанартай юмаар ашигтай мэдээлэл сонсох гэсэн үзэгчдийн урмыг хугалж суудгийн баримт энэ мөн.

МҮОНТ-ийн нэвтрүүлгийн хэл найруулгын алдаа бараг хэм хэмжээ болчихсон. Ёстой л нөгөө «Өр мянга хүрэхээр санаа амардаг» гэгчийн үлгэр

болсон. “Улаанбаатар” төмөр замын дарга 2015 оны 7 дугаар сарын 31-ний «Цагийн хүрд»-д яриа өгөхдөө «Хүнд даацын урт жинтэй галт тэрэг хэрэглэнэ» гэж яриу. Энэ бол зочны үг. Мэдээллийн хэрэгсэлд, тэр тусмаа телевизэд яриа өгч байгаа хүний үг яриаг засч найруулах боломжгүй. Та буруу ярилаа ч гэх аргагүй. Харин сэтгүүлч, нэвтрүүлэгч нарт тэс өөр шаардлага тавигддаг. Тэд товч тодорхой, яруу сайхан, хэл найруулгын алдаагүй ярьж, бичих үүрэгтэй. Гэтэл тийм байж чадахгүй байна. «Цагийн хүрд»-ийн нэвтрүүлэгч Одзаяа «Монголын төмөр зам 77 жилд 540 сая тонн ачаа, 124 сая зорчигчид үйлчилжээ» гэж уншлаа. Зорчигчид үйлчилж болно, харин ачаанд яаж үйлчилдэг юм бол! Мэдээж энэ бол сэтгүүлчийн бэлтгэж өгсөн бичвэр. Гэвч чадвартай, туршлагатай нэвтрүүлэгчид эфирт гарахын өмнө бичвэртэйгээ танилцаж хаана нь өргөж, хаана нь тасалж, ямар өнгө тоноор уншихаа тогтдог, тулгамдсан үед иймэрхүү алдааг шууд засаад уншихдаг рефлексстэй болчихсон байдаг.

2015 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн «Спортын мэдээ»-гээр «”Чингис хаан гран при” тэмцээн “Буянт ухаа” спорт цогцолборт гурван өдөр үргэлжилж, өнөөдөр отголлоо» гэж яриу. Айлын хамгийн бага буюу сүүлд гарсан хүүхдийг отгон гэдэг. Харин тэмцээн отголлоо гэвэл дахиад хэзээ ч ийм тэмцээн болохгүй гэсэн санаа илэрхийлнэ. Түүний оронд “тэмцээн өндөрлөлөө”, “тоглолт дууслаа” гэх мэтээр яриуал зөв болно. Энэ оны 7 дугаар сарын 4-ний «Спортын мэдээ»-ний хөтлөгч «Монгол улсын нийслэл Улаанбаатар хотод “Чингис хаан гран при” тэмцээн болов» гээд ярьж байх юм. Өөрөө хаанахын иргэн болчихоод

ийнхүү хүнийссэн өнгө аясаар харийн хүн шиг ярьж байгаа юм бол гэж өөрийн эрхгүй бодогдоно.

«Цагийн хүрд»-ийн урсдаг мэдээ үг үсэг, найруулгын алдаагүй байх нь нэн ховор. 2015 оны 7 дугаар сарын 15-ны «Цагийн хүрд»-ийн урсдаг мэдээ «”Миний гэрээс манай аймгийн хөгжил эхлэнэ” аян Увс аймагт эхэллээ» гэж байх юм. Аравхан үгтэй өгүүлбэрт нэг үгийг хоёр янзаар биччихээр үзэгч алиныг нь зөв гэж бодох вэ? Мөн 9 дүгээр сарын 27-ны «Цагийн хүрд» нэвтрүүлгийн доогуур «Чөлөөлөх дайны 70 жил», «Эрдэм шинжилгээний болж байна», мөн өдрийн 18:00 цагийн мэдээнд «Ирэх 24-ний өдөр цэцэрлэгийн хүүхдийн бүртгэл эхэлнэ» гэсэн бичгүүд явж байлаа. Эхнийхэд хайхрамжгүйгээс “хурал” гэдэг үг орхигдсон бол, хоёр дахь өгүүлбэрт бүртгэл нь эхлээд гурав хонож байхад “эхэлнэ” гэдэг үг хэрэглэсэн нь бичмэл мэдээгээ сольдоггүйн гэрч болов.

Алдаа үүгээр дуусахгүй. 2015 оны 9 дүгээр сарын 8-ны «Цагийн хүрд»-д «Манай иргэд Улаан-Үд хотод очиж худалдан авалт хийлээ», «Эрдэнэтийн хивсний үйлдвэр Чингис бондоос санхүүжилт авч үйлдвэрлэлээ өргөтгөв» гэх мэт үг, өгүүлбэр явж байх юм. Үйл үгийг өгүүлбэрийн араг яс, амь оруулагч гэдэг. Үйлээс нэр үүсгэдэг “лт” дагаврыг хэрэгцээгүй газарт хэрэглэснээр өгүүлбэрийг идэвхгүй болгож, үйл үгийг сөнөөх аюултай. “Худалдан авалт”, “санхүүжилт” гэх нь “бие засалт”, “хоол идэлт” гэсэнтэй адил болно. Энэ тохиолдолд «Улаан-Үд хотоос бараа худалдан авлаа», «Чингис бондоос санхүүжиж үйлдвэрлэлээ өргөтгөв» гэх мэтээр биччихэж болох байв. Сонин, телевиз зэрэг мэдээллийн хэрэгсэл иргэдэд ямар нэг хэмжээгээр албан бус

боловсрол олгож, ялангуяа сурагч багачуудад зөв бичгийн эталон болж байх учиртай. Энэ тухайд үндэсний телевизэд найдах хэрэггүй аж. Үндэсний телевизийн зарим нэвтрүүлэгч «Цагийн хүрд»-тэй хамт байсанд баярлалаа» гэж нэвтрүүлгээ төгсгөдөг нь хачирхалтай. Хаачиж яваад ирэв гэж асуухад “кинотой хамт байлаа”, “зуслантай хамт байлаа” гэж хариулах уу?

Үүнээс гадна «Өчигдөр нээлтээ хийж, маргааш аваргаа тодруулах юм байна», «Бохирыг шүүж хөрсний аюулгүй байдлыг гадагшлуулдаг», «Хөдөөгийн ард иргэдийн амьдралыг бууруулах төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх», «Дархан хотод сурч байгаа арав шахам их, дээд сургуулийн оюутнууд», «Энэ тэмцээнд Монголын долоон ширэн бээлийтэн оролцлоо», «Цахилгааныг таслах арга хэмжээ авсантай холбоотой», «3000 Курдын босогч нуугдаж байна», «Тэрээр өнгөрсөн 7 дугаар сард мэс хагалбарын ажилд орсон», «80 настай Куба улсын тэргүүн Фидель Кастро» гэх мэтээр ярьж, бичиж байгаагийн зөв, бурууг мэргэн үзэгчид тунгаах биз ээ.

Үндэсний телевизийнхэн хайнга, хариуцлагагүйн зуданд нэрвэгдсэн байдал илэрхий харагддаг. Олон баримт дурдаж болох боловч ганц хоёрыг жишээлье. 2015 оны 4 дүгээр сарын 11-ний «Цагийн хүрд» нэвтрүүлэгт дараалан яриа өгсөн эрэгтэй, эмэгтэй хоёр хүн «Аймгийн хөдөлмөрийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Сүмбэр» гэсэн ижилхэн хаягтай гарав. Мөн оны 6 дугаар сарын 12-ны «Цагийн хүрд» нэвтрүүлгийн доогуур «СХД-ийн 120 мянган иргэн халдварт бус өвчнөөр урьдчилан сэргийлэх шинжилгээнд хамрагдана» гэсэн бичиг гарч байх юм.

Алив юм хариуцлагатай байх цагт «Сэтгүүлч хүн ганц үсэгний амьтай» гэсэн үг байсан. Ганц үсэг алдсанаас болж хоолноосоо салдаг байсан үе ч бий. Энэ удаад ч гэсэн “өвчнөөс” гэдгийн “с” үсэг “р” үсгээр солигдсоноос болж өвчнийг хэрэгсэл болгон ашиглаж урьдчилан сэргийлэх гэсэн инээдтэй утга гарч ирж байна.

Манай төр засаг, соёл, боловсрол, мэдээллийн аль ч байгууллагад нам дагасан хэдэн нөхдүүд нэг нэгнийгээ ойр ойрхон мөргөж, тухайн салбарын бодлогын залгамж чанарыг алдагдуулан, баруун зүүн тийш савлуулж байдаг нь ёс мэт болсныг хүн бүхэн мэднэ. МҮОНРТ энэ гажуудалд хамгийн түрүүнд өртдөг газрын нэг. Өнөөгийн нөхцөлд нөгөө хараат бус, ил тод байдал, олон нийтийн эрх ашгийг дээдлэх тухай зүүдлэх ч хэрэггүй. Учир нь аль ч улс төрийн хүчнээс хараат бус, зөвхөн үндэсний эрх ашгийг дээдлэх зарчмаар бодлогоо боловсруулж, үгээ хэлэх учиртай энэ газарт эрх баригч нам Ерөнхий нарийн бичгийн даргаа аваачаад тавьчихсан. Тэр хүн нь монгол телевизийн эфирээр өөр үзэл бодлын салхи нэвтрүүлэхгүй байх “хоточ нохой”-н үүргээ үнэнчээр биелүүлж байгаа. Улс орны эдийн засаг шалдаа унаж, иргэдийн амьдрал тартагтаа тулаад байхад үндэсний телевиз төр засгийн урагшгүй үйл ажиллагаа, улс төрчдийн бусармаг явдлыг шүүмжилж ганц үг ч дуугарахаа больсон. Шуудхан хэлэхэд ардчилсан намыг магтах хэрэгсэл болж хувирсан.

Улс төрийн тогоонд болж байгаа санал зөрөлдөөн, далд, маргаантай асуудал, олон нийтийн шүүмжлэлд өртөж байгаа шийдвэр, жирийн иргэдэд нүүрлэсэн амьдралын хүчирдэл зэргийн уг шалтгааныг илчилсэн шүүмжлэлтэй, дүн шинжилгээтэй нэвтрүүл-

гийн сураг тасарсан гэж хэлж болно. Эрх баригчдын гаргасан шийдвэр, хэлсэн үгийг ямар ч эргэлзээгүйгээр тоть шиг давтана. Ерөнхий сайд Дубайд Оюу толгойн гэрээнд нууцаар гарын үсэг зурлаа, Таван толгойн гэрээг УИХ-ын дарга гацаалаа, Ардчилсан намынхан Өршөөлийн хууль гаргаж авлигачдыг суллах гэлээ, Намбарын Энхбаяр үе үе ирж Монголын улс төрчдийг бужигнууллаа гэх мэт иргэдийн анхаарал татсан ээдрээтэй асуудлын учрыг олж, учгийг тайлах нь олон нийтийн эрх ашгийг дээдэлсэн үндэсний телевизийн үүрэг баймаар. Эрх баригчдын мөрийг мөшгөж, мөчийг тоолон буруу үйлдэл хийлгэхгүй байх “хоточ нохой” болж, хяналтаар хөллөсөн “дөрөв дэх засаг” байх үүрэг үнсэнд хаягдсан. Энэ мэт ээдрээтэй асуудлыг хөндөх гэхээр буруу нь эрх барьж байгаа нам дээр буух гээд байдаг учраас эрс зайлсхийж, эсэн бусын юмаар ард олны тархийг угааж суудаг болжээ.

Эдгээр асуудлыг хаа ч гэж арилжааны телевизүүд боломжийн хэрээр тусгаад байдаг. Тэд чөдөртэй биш, чөлөөтэй болохоор тэр. Энэ жил тэтгэврийн насыг нэмэх хуулийн төсөл УИХ-д орж ирэхэд ард түмэн эрс эсэргүүцэж, арилжааны телевизүүд дуу дуугаа аван шүүмжилцгээж байхад МҮОНТ таг чиг. Учир нь эрх баригч намын шийдвэрийг сөрж болохгүй. «Эрдэнэс таван толгой»-г «Энержи ресурс»-тэй нэгтгэхийг Үйлдвэрчний эвлэл нь эсэргүүцэж, ажилчид нь дуу хоолойгоо нэгтгэв. Үндэсний телевиз энэ талаар үг дуугараагүй мөртөө «Энержи ресурс»-ийг баахан магтаж байх жишээтэй.

Бүхнийг болж бүтэж байгаагаар харуулж, ард иргэдийн ядуурал, өлөн зэлмүүн амьдралыг мартуулах, тийм

тарчиг байдалд хүргэсэн буруутныг хаацайлах нэг арга олсон нь “монгол контент”. Телевизийг мэдээллийн хэрэгсэл гэхээсээ илүү уран бүтээл туурвидаг газар болгох юм гэнэ. Арай л телевизийг театр болгочихъё гэх нь холгүй байх шиг. Тэр кампанит ажлын эхлэл болгож өнгөрсөн хавар «Цэнхэр дэлгэц» нэртэй телевизийн богино хэмжээний бүтээлийн наадам гэгчийг зохион байгуулав. Тэдгээр бүтээлийн дотор нийгмийн тулгамдсан асуудлыг нийтлэл-уран сайхны аргаар хөндсөн ажил хэрэгч, үр нөлөөтэй бүтээл бараг үзэгдсэнгүй. Бүгд цэвэр уран сайхны бүтээл байв. Хамгийн хачирхалтай нь тэр наадамд нь «Гандаагүй сэтгэл» гэсэн нэрнээсээ эхлээд ойлгомжгүй бүтээлэнцэр шалгараад цохиж явав. Сэтгэл ганддаггүй харин гунддаг. Гандах гэдэг нь дээл хувцас, эд хэрэглэл нар салхинд өнгөө алдаж өгөрч цайхыг хэлдэг. Гундах гэдэг нь таагүй явдлаас болж хүний сэтгэл гутарч, уруу дорой бодол санаатай болохыг хэлдэг. Нэг нь өнгөний, нөгөөх нь дотоод сэтгэлийн хувирал өөрчлөлтийг илэрхийлсэн ойлголт юм. Уралдаанд шалгарсан уран бүтээлчид, түүнийг шүүн тунгаасан мэргэдэд ингэж хичээл заах нь угтаа илүүц юм. Гэвч хэлэхээс өөр арга байсангүй.

Тэрхүү сүр бадруулаад байсан “монгол контент” нь өнөөг хүртэл сайн харагдаж өгөхгүй л байна. Дашрамд дурдахад “контент” гэж нэг гадаад үг гаргаж ирээд гангарцгаах болж. Тэгээд очиж очиж “монгол контент” байдаг нь ч юу билээ. Нэртэйгээр нь “монгольский контент” гэхихгүй дээ гэхэд, нэг нөхөр «Яалаа гэж тэгдэг юм. Монгол хэл, гадаад хэл хоёрын тэнцвэрийг барьж байхгүй юу» хэмээн хошигнож байна билээ. “Контент” гэдгийг орлочих монгол үг

олдохгүй байгаа юм болов уу даа. Уг нь нэг гадаад үг орж ирэхэд нэг монгол үг “үхэж” байдаг. Үг үхнэ гэдэг үндэстэн мөхөхийн цондон гэдэг сэн.

Энэ улс орон яана даа гэсэн иргэдийн сэтгэлийн зовлонг мартуулах гэсэн шиг Хүннүгийн модон цуур, баруун монголын тоохуу гутал гэх мэтийн юм ярьж цаг нөгчөөдөг болсон. Хамгийн хачирхалтай нь цуурыг яаж дуугаргах, хэрхэн хийж бүтээх тухай яриад байх юм. Ямар хэдэн хүн цуглуулчихаад хөгжмийн дугуйланд хичээл зааж байгаа биш. Энэ нь урлаг, шинжлэх ухааны мэргэжлийн байгууллага, судлаач, урчуудын хийх ажил баймаар. Арай монголын ард түмнийг бүгдийг нь цоор урлаач, цоор хөгжимчин болгох гээгүй баймаар санагдана. Ингэж байхын оронд цоор хөгжмөөр тоглосон хэдэн сайхан ая дуу сонсгочихвол үзэгчид сэтгэлийн таашаал авч, алжаалаа тайлах биз.

Үндэсний телевизийн тогтмол, тоймтой нэвтрүүлгүүдийн нэлээд нь долоо хоногт нэгээс хоёр удаагийн давтамжтай гарч байгаа харагддаг. Уран бүтээлчид нь ч тэр л үед эфирт үзэгдэж байдаг. Удаж удаж нэг часхийсэн юм хийгээд байна уу гэхээр санаанд хүрэх нь цөөхөн. Аль тэртээх дал, наяд оны «Агшин», «Дөрвөн бэрх» гэх мэтийн улиг болсон юмнуудаа гаргаж, салбарын захиалгаар хийсэн сериал нэртэй “савангийн дуурь”-тай төстэй цувралуудаа орой бүр тасартал хөрөөдөх нь яршигтай. Олон ангит уран сайхны кино гээд байгаа тэр цувралууд дотор нь салбарын яам, тамгын сайд, дарга нар нь хурал цуглаанаа хийгээд, амжилт дутагдал, тоо баримт яриад сууцгааж байдаг. Жишээ нь эрүүлийг хамгаалахын сэдэвтэй уран сайхны кинонд Ламбаа сайд нь орчихсон цохиж

явахаар юу болох вэ, сайд өөрөө сайдын дүрд тоглосон болох уу? Ийм уран сайхны кино байдаг юм уу! Нөгөө тунхаглаад байсан “монгол контент” нь нэг иймэрхүү л байдалтай “цэцэглэж” байх шиг.

Ёстой л мөнөөх УИХ-ын даргын хэлсэнчлэн 800 хүн ажилладаг нүсэр бүтэцтэй байгууллага гэхэд орлого хөөдөг гэх муу нэртэй арилжааны зарим телевизээс гавьтай ялгараад, үндэсний хэмжээний телевизийн буурь заагаад, ур чадвар нь илт мэдрэгдээд байгаа нэвтрүүлэг төдий л олон харагдахгүй байгааг мэдээллийн өндөр шаардлагатай үзэгчид шүүмжлэн хэлэлцэж байгааг тус телевизийн удирдлагууд мэддэг болов уу, үгүй болов уу?

МҮОНТ-ийн үйл ажиллагааг хатуухан хэлэхэд хаячихъя гэхээр урагддаггүй, өмсчихье гэхээр өнгө зүс нь гандчихсан азарган үстэй хуучин нэхий дээлтэй зүйрлэж болох мэт санагдана. Дүлийдээ найдаж... гэдэг шиг энэ янзаараа яваад байвал араас чинь эрчтэй нэхэж яваа арилжааны телевизүүдэд гартаж нүүрээ улайлгах цаг ойрхон байгааг сануулъя.

Резюме

В данной рецензии автор анализирует передачи и программы Общественного телевидения Монголии, в частности, качество и эффективность информационного выпуска. ОТМ, хотя и оснащён новейшими техническими оборудованиями и обладает достаточно потенциальными кадрами, оно не превосходит по качеству выпуска коммерческие телевидения. Новостные передачи ОТМ не выходят за стереотипные рамки, недостаточно используются новые, эффективные методы подачи информации и разнообразие жанров, выбор тем скуден, а информационная насыщенность, оперативность, стиль и язык оставляют желать лучшего.